


Кино урлагийн зөвлөлийн ажлын алба нь Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэх үндсэн чиг үүрэгтэйгээр дараах зохион байгуулалт бүтэцтэйгээр ажиллаж байна.

Ажлын алба нь дараах зохион байгуулалтын бүтцийн нэгжтэй байна.



Ажлын алба нь дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ

- ✓ Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах;
- ✓ Холбогдох байгууллага, Зөвлөлийг шаардлагатй мэдээлэл судалгаагаар хангах;
- ✓ Кино урлагийг дэмжих тухай хуулийн 20.1-д заасан зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд болон зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж, санал дүгнэлт гаргах;
- ✓ Зөвлөлийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар холбогдох баримт бичгийн төсөл боловсруулах;
- ✓ Зөвлөлийн шийдвэрийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх;
- ✓ Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Кино урлагийг дэмжих сангаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн ерөнхий нөхцөл, хамрах хүрээ, тавигдах шаардлага, мэдүүлэг гаргах зааварчилгааг бэлтгэх, мэдээлэл зөвлөмж боловсруулах;
- ✓ Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийн дагуу төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх этгээдтэй гэрээ байгуулах арга хэмжээг зохион байгуулах, хяналт тавих;
- ✓ Кино урлагийг дэмжих тухай хуулийн 10.1-д заасан Кино урлагийн мэдээллийн сангаар дамжуулах кино урлагийн үйл ажиллагаанд холбогдох мэдээллийг түгээх, сурталчлах;



- ✓ Салбарын хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулахад мэргэжлийн төрийн бус байгууллага, уран бүтээлчийн саналыг авах ажлыг зохион байгуулах;
- ✓ Холбогдох хууль, журмын дагуу Кино урлагийг дэмжих сангийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжилтийг тайлагнах;
- ✓ Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг
- ✓ Ажлын албаны нэгжийн чиг үүргийг Зөвлөлөөс тогтооно.